



ХЭНТИЙ АЙМГИЙН  
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/36

Мөрөн сум

Төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд  
хяналт, шалгалт хийх байнгын ажлын хэсэг  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59.1.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх хэсэг, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх, зөвлөн туслах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Г.Хишигбаатар - Хууль, эрх зүйн дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Гишүүдэд: Ө.Өнөрөө - Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Долгорнямаа – Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн

Г.Энхцэцэг – Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан

Г.Дашмаа - Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

2.Сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд "Дотоод хяналт шалгалтыг, зөвлөн туслах үйлчилгээг зохион байгуулах удирдамж"-ийг хууль, эрх зүйд нийцүүлэн боловсруулж батлуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

3.Сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд "Дотоод хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг жил бүр хоёроос доошгүй удаа хагас, бүтэн жилээр зохион байгуулж, Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн хуралд ажлын 5 хоногт багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

4.Ажлын хэсгийн хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг хийхэд шаардагдах бичиг баримт, холбогдох албан тушаалтнуудыг бэлэн байлгахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

5.Хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг хийх удирдамжийг төсөвт байгууллагуудад хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэхээс ажлын тав хоногийн өмнө хүргэж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Н.ХАТАНБААТАР



БАТЛАВ  
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Н.ХАТАНБААТАР  
2026 оны 03 дугаар сарын 02

УДИРДАМЖ

2026.03.02

Мөрөн сум

Сумын төсөвт байгууллагуудад хяналт шалгалт,  
зөвлөн туслан үйлчилгээг үзүүлэх тухай

### Нэг: Зорилго

Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа нь хууль, тогтоомж, журмын хүрээнд хэрэгжиж буй эсэх, салбар бүрт бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдаж буй эсэх, байгууллагын дотоод зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үйлчилгээний чанар, иргэдэд үзүүлж буй үйлчилгээний хүртээмжид хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах, сайжруулах арга хэмжээг тодорхойлох.

### Хоёр: Хамрах хүрээ

Хамрах хүрээ: Сумын нийт төсөвт байгууллага

Хугацаа: 2026 оны 03 дүгээр сарын 10-11

Хамрах асуудлууд:

- Бодлогын баримт бичгийн хэрэгжилт
- Тогтоол шийдвэрийн хэрэгжилт
- Байгууллагын үйлчилгээний стандарт
- Албан хэрэг хөтлөлтийн стандарт
- Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, тайлан
- Хүүхдийн эрүүл аюулгүй байдлыг хангах, байгууллагын орчны камержилт,
- Санхүү, төрийн сан
- Иргэдийн санал гомдлын бүртгэлтэй танилцах
- Үйлчилгээ үзүүлж буй орчныг үнэлэх

### Гурав: Хугацаа

Эхлэх огноо: 2026 оны 03 дугаар сарын 10

Дуусах огноо: 2026 оны 03 дугаар сарын 11

### Дөрөв: Зөвлөн туслах үйлчилгээний үр дүнг танилцуулах

Зөвлөн туслах дүнг нэгтгэн дүгнэж, 2026 оны 03 дугаар сарын 16-ны дотор Засаг даргын зөвлөлд тайлагнах бөгөөд илэрсэн зөрчлийг арилгуулах, сайжруулах зөвлөмж хүргүүлэн ажиллана.

АЖЛЫН ХЭСЭГ